

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2024 оны 2 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт дүн
1	Нийт үзлэг	27442	14651	16474	10559		69126
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	3569	3887	7501	1279		16236
3	Идэвхтэй хяналтын үзлэг	2150	1888	5646	583		10267
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	8751	4136	1568	2940		17395
5	Нийт төрөлт	174	29				203
6	Хэвтэн эмчлүүлэгчид	1442	1047		519		3008
7	Нас баралт	5	28	14			47

№	Үзүүлэлт	2023.2	2024.2	Өөрчлөлт
1	Нийт үзлэг	60511	69126	8615
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	11224	16236	5012
3	Идэвхтэй хяналтын үзлэг	4369	10267	5898
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	19146	17395	-1751
5	Нийт төрөлт	216	203	-13
	Гэрийн төрөлт	2	0	-2
6	Хэвтэн эмчлүүлэгчид	2765	3008	243
7	Нас баралт	51	47	-4
	0-1 насны эндэгдэл	0	5	5
	1-5 насны эндэгдэл	0	0	0
	Хурц халдварт өвчин	99	202	103

Үзүүлэлт	хэмжих нэгж	2023.2 сар	2024.2 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	0	24.6	24.6
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	232.5	453.2	220.7
<b>Үүнээс охидын</b>	хувь	4	5.4	1.4
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	13.4	26.7	13.3
БЗДХ	10000 хүн амд	4.3	7.2	2.9
<b>Үүнээс өсвөр үе</b>	хувь	18.7	14	-4.7
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	72.7	77.6	4.9
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	36.4	39.9	3.5

I.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 69126 хүнд үзлэг шинжилгээ хийсний 23.4 %-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 3008 хүнийг 18777 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.2 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 1559 дуудлагад явж үйлчилсний 320 (20.5%) нь алсын дуудлага, 132 (8.4%) нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна.
- Нийт эмийн сангууд 18322 жор хүлээн авч, 2.6 тэрбум гаруй төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 2076 жор ирсний 53.6% (1111) нь ЭМДаатгалын, 0.3% (27) мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 45.1% (938) нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 64,1% байна.

## II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

1. 2 сарын байдлаар 17395 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1751 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 73.3% нь шинэ өвчлөл байна.
2. **Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:**
  1. Амьсгалын тогтолцооны өвчин-4599
  2. Хоол шингээх эрхтний өвчин-3904
  3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-1621
  4. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-1103
  5. Арьс харшил-940
  6. Мэдрэлийн тогтолцооны өвчин-870
3. 2 сарын байдлаар 301 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба өвчлөл өнгөрсөн оноос 103 тохиолдолоор өссөн байна.
4. Оны гарсаар 47 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 14,8% нь хорт хавдраар, 21,2 % нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 12,7% нь осол гэмтэлээр, 6,3 нь чихрийн шижин өвчнөөр тус тус нас барсан байна. Нийт нас баралтын 13 нь эмнэлэгт, бусад нь гэртээ хээр гадаа нас барсан байна.
5. БОЭТөвд 5 эндэгдэл тохиолдож 4 задлан шинжилгээнд хамруулсан ба задлан шинжилгээний хувь 80 % тай байна. Үндсэн оношийн зөрөө байхгүй.
6. **Нас баралтын шалтгаан:**
  1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-17
  2. Хорт хавдраар-7
  3. Осол гэмтлээр-6
  4. Амьсгалын тогтолцооны өвчин-3
  5. Хоол шингээх эрхтний өвчин-5
  6. Чихрийн шижин-3
  7. Мэдрэлийн тогтолцооны өвчин-2
  8. Бөөрний архаг дутагдал-2
  9. Перинаталь үеийн эмгэг-1
  10. Төрөлхийн гажиг-1

## III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 203 эх төрж 205 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 13 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 3,9 % (8) дутуу төрөлт эзэлж байна.
- Нийт төрөлтийн 7,8% (16) охидын төрөлт эзэлж байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс (3/1,3%) 6,5-р нэмэгдсэн үзүүлэлт байна.(ДЗ-9, ГТ-1 Мн-1,ЦЦ-3 бусад газар 2).
- 2 сарын байдлаар 92 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 453,2 байгаа нь өнгөрсөн оноос 220,7-р өссөн үзүүлэлт байна.
- 260 жирэмсэн эх хяналтанд шинээр орсны 235 (90,3%) эрт, 4(1,5%) хожуу хяналтад орсон байна.
- Нялхсын эндэгдэлын 5 тохиолдол бүртгэгдсэн нь нярай 1, 1-6 сартай-4 байна. Эндэгдэлийн шалтгаан нь суулгалт, осол гэмтэл-2, зүрхний гажиг, нярайн амьсгалын гачаалын шалтгаантай байна.
- 2 сарын байдлаар 6719 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 58,7% эзэлж байна. Хяналтад хамрагдсан хүүхдүүдээс 8 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байгаа ба 19 хүүхэд туранхай, 10 хүүхэд өсөлт хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 77,7%, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 39,9%-тай байна.

#### IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 257 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 124 тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний 22.1%-г БЗДХ, 56.4%-г салхинцэцэг, 0.7%-г цусан суулга, 15.5%-г гар хөл амны өвчин, 2.4%-г ёлом 4.2 %-г ковид зэрэг өвчнүүд тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 8.7% (5) нь жирэмсний үзлэгээс, 14% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 80.7% нь өвчний учир амбулатороор, 5.3% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

#### АНХААРАЛ ТАТСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. 1000 амьд төрөлтөд нялхасын эндэгдэл 24.6-р (5) нэмэгдсэн.
2. 1000 амьд төрөлтөд үр хөндөлт өнгөрсөн оноос 220.7-р өссөн.
3. Охидын төрөлт, үр хөндөлт өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдэх хандлагатай анхаарал татаж байна.
4. Нас баралт, ялангуяа сэргийлж болох хавдар, чихрийн шижин, тархинд цус харвалт, зүрхний шигдээс, багтраа, осол гэмтэл, архины хордлого зэрэг шалтгаант нас баралт нийт нас баралтын 85% эзэлт байна. Хорт хавдарын нас баралтын 71% нь оношлогдсоноос хойш 1 хүртэлх жил амьдарсан байна.
5. Осол гэмтэлд өртөгсөдийн тоо өнгөрсөн оноос 1,5 дахин нэмэгдсэн байна.
6. Халдварт өвчин өнгөрсөн оны мөн үеэс 1,9 дахин нэмэгдсэн ба энд БЗДХ, салхинцэцэг, гар хөл амны авчин өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдсэн байна.
7. Хүүхдийн хяналтын хувь өнгөрсөн оны мөн үеэс буурсан ба өсөлт хоцролттой, жингийн алдагдалтай, туранхай хүүхдийн тоо нэмэгдсэн байна.

**Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох**

**2024 оны 3 сарын 5**

